



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”  
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг  
өөрчлөн байгуулж, дүрмийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсантай холбогдуулан хууль, тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 146 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН

1110100900

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 37  
дугаар тогтоолын хавсралт

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ  
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү дүрэм нь “Багануур үйлдвэрлэл технологийн парк” хувьцаат компани (цаашид “компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн.

1.2. Компанийн оноосон нэр нь “Багануур үйлдвэрлэл технологийн парк” хувьцаат компани буюу товчилсон нэр нь “БҮТП” ХК, (англиар “Baganuur Industrial and Technology Park” closed joint-stock company, товчилсон нэр нь “BITP” closed JSC )

1.3. Компани нь орон нутгийн өмчийн оролцоотой, хаалттай хувьцаат компани байна.

1.4. Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа буюу гүйцэтгэх удирдлага байршиж байгаа газрын хаягаар тодорхойлно.

1.5. Компани нь өөрийн бэлгэдэл (лого, туг)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

**ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

2.1. Компани нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үйлдвэрлэл, Технологийн Паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд байна.

2.3. Хувьцаа эзэмшигч компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг хүлээхгүй.

**ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ**

3.1. Компани нь байгальд ээлтэй, өндөр технологи бүхий аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, импортыг орлох, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байруудыг шинээр нэмэгдүүлэн, Нийслэлийн хүн амын болон үйлдвэржилтийн хэт төвлөрлийг бууруулахад тодорхой нөлөөлөл бий болгож, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд дэвшүүлэх зэрэг үндсэн зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**3.1.1. Хүнд үйлдвэрлэл:**

3.1.1.1. Хүрэн нүүрс гүн боловсруулах “Нүүрс – химийн” үйлдвэрлэлийн кластер цогцолбор (Нүүрс баяжуулах үйлдвэр, Нүүрс хийн түлшний үйлдвэр, Нүүрс шингэрүүлэх үйлдвэр, Хагас коксжуулсан нүүрсний үйлдвэр, Химийн үйлдвэр)

3.1.1.2. Ашигт малтмал, эрдэс бодис баялаг хөрс шороог гүн боловсруулах үйлдвэрлэлийн кластер цогцолбор /Барилгын материалын үйлдвэрлэл, Гумины бордоо болон тэсэлгээний материалын үйлдвэрлэл, Төрөл бүрийн хайлшны үйлдвэрлэл,

3.1.1.3. Авто замын бетон, асфальт бэлдцийн үйлдвэр

3.1.1.4. Уул уурхайн болон эрчим хүчний техник, тоноглол, материалын үйлдвэрлэл

### 3.1.2. Хөнгөн үйлдвэрлэл

3.1.2.1. Ноос, ноолуур гүн боловсруулах үйлдвэрлэлийн кластер цогцолбор (Ноос самнах ялгах үйлдвэр, Ээрмэл утасны үйлдвэр, хивсний үйлдвэр, Хувцасны үйлдвэр, Техникийн, барилгын, ахуйн ноосон дулаалгын материалын үйлдвэрлэл)

3.1.2.2. Хөнгөн бетон, арматур хийцийн үйлдвэрлэл

3.1.2.3. Мод боловсруулах, модон эдлэлийн тавилгын үйлдвэр

### 3.1.3. Ургамал – нано-биотехнологийн үйлдвэрлэл

3.1.3.1. Ургамал – нано биотехнологийн үйлдвэрлэлийн кластер цогцолбор (Эмийн, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний, Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэр)

3.1.3.2. Био органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн кластер цогцолбор (Ургамлын биотехнологийн судалгаа, хөгжлийн төв, Компост органик бордооны үйлдвэр, Бактерийн шингэн бордооны үйлдвэр, Мөөг боловсруулах үйлдвэр)

3.1.3.3. Ургамлын эс, эд өсгөврийн лаборатори үйлдвэр

3.1.3.4. Ургамлын үрийн сан, генофондын нэгдсэн сан (Хөрсний микро организмын генофонд)

3.1.3.5. Цаг агаараас үл хамаарах биотехнологийн хүлэмжийн, зоорийн цогцолбор /Мөөг үржүүлгийн өвлийн хүлэмж, Ховор ургамлын өвлийн хүлэмж/

3.1.3.6. Адуу брэндийн үйлдвэрлэлийн кластер цогцолбор

(Органик материал боловсруулах үйлдвэр, Саам боловсруулах үйлдвэр, Саам хүлээн авах, ариутгал, хөргөлттэй агуулах, Эмийн үйлдвэр, Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэр, Логистик төв, Дайвар хүлээн авах, анхан шатны боловсруулах үйлдвэр, Яс хүлээн авах, анхан шатны боловсруулах үйлдвэр, Яс хадгалах хөргөлттэй зоорь, Захиргаа судалгаа хөгжлийн төв, Үзэсгэлэн хурлын танхим, Харуул хамгаалалтын алба, Ариутгалын бүхээг, орох гарах хаалга, Мал эмнэлгийн алба)

### 3.1.4. Хүнсний үйлдвэрлэл

3.1.4.1. Мах, сүү гүн боловсруулах үйлдвэрлэлийн кластер цогцолбор /Хуурай сүүний үйлдвэр, Гурил тэжээлийн үйлдвэр, Мах боловсруулах, лаазлах үйлдвэр/

3.1.4.2. Ногоо нөөшлөх үйлдвэр

3.1.4.3. Төрөлжсөн Зоорь

3.1.4.4. Хүлэмжийн цогцолбор

3.1.4.5. Бохир ус цэвэрлэх байгууламж

## ПАРК АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

3.2. Парк ашиглалтын техник-эдийн засгийн үндэслэл, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх, түүнтэй уялдуулан Паркийн хөгжлийн төлөвлөгөө болон дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрийг бие даан болон бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдах;

3.3. Паркийн ложистикийн үйлчилгээ, бүтээгдэхүүн тээвэрлэх, дамжуулан тээвэрлэх, агуулахын болон гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ эрхлэх;

3.4. Паркийн эзэмшил газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Паркийн нэгжүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах;


### 3.5. Тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах чиглэлээр:

3.5.1. Парк ашиглалттай холбоотой аливаа эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, түрээслүүлэх, худалдаж авах, худалдах;

3.5.2. Барилга байгууламж, бусад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, барих, эзэмших, ашиглах, түрээслэх, барьцаалах;

### 3.6. Санхүүжилт татах, олгох чиглэлээр:

3.6.1. Парк ашиглалт болон энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Компани нь өөрийн үндсэн орлогоос гадна улсын болон нийслэлийн төсвөөс тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан хуваарилсан хөрөнгө, компанийн үнэт



цаасыг гадаад, дотоод зах зээлд гаргаж худалдсаны орлого, авсан зээл, гадаад дотоодын иргэд байгууллагаас компанийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд зориулан өгсөн хандив, тусламж, холбогдох хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого зэргээр "Паркийн хөгжлийн сан" бүрдүүлэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, бусад хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах;

3.6.2. Хувьцааг нь эзэмшдэг Паркийн нэгжид зээл олгох, бусад хэлбэрээр хөрөнгө оруулах;

3.6.3. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр өрийн бичиг (бонд) гаргах;

3.7. *Борлуулалт, худалдааны чиглэлээр:*

3.7.1. Паркад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаад, дотоод зах зээл дээр борлуулах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах;

3.8. *Зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:*

3.8.1. Парк ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, техник технологийн түвшний үнэлгээ хуулийн хугацаанд хийлгэх, Паркийн нэгжүүдийн төслүүдэд шаардлагыг хангуулах

3.8.2. Паркийн нэгжүүдэд УТП-н хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг үзүүлэх, стратегийн хөрөнгө оруулагчийг татахад дэмжлэг үзүүлэх

3.8.3. Паркийн удирдлагын болон паркийн нэгжүүдийн тухай мэдээллийг дотоод, гадаадад сурталчлан таниулах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

3.8.4. Компани нь хуулиар хориглоогүй бусад аливаа үйл ажиллагааг эрхлэн явуулж болно.

3.9. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.

3.10. Компани нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

3.10.1. бие даасан байх;

3.10.2. олон нийтэд ил тод байх;

3.10.3. байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашигт автагдахгүй байх.

#### **ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬЦАА, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ**

4.1. Компанийн нийт хөрөнгө нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан үл хөдлөх ба хөдлөх хөрөнгөөс бүрдэх ба тогтоосон хувьцааны тоо ширхгээр үнэлэгдсэнээр Компанийн нийт зарласан хувьцааны тоо нь 109'425'839 (нэг зуун есөн сая дөрвөн зуун хорин таван мянга найман зуун гучин ес) ширхэг энгийн хувьцаа байх бөгөөд хувьцаа тус бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна. Нийт хувьцааны үнэ 109'425'839,000 ( нэг зуун есөн тэрбум дөрвөн зуун хорин таван сая найман зуун гучин ес мянган) төгрөг.

4.2. Компанийн хөрөнгийн хэмжээ нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнтэй тэнцүү байна.

4.3. Компанийн хувьцаа нь биет бус хэлбэртэй байх бөгөөд компани нь энгийн хувьцааны бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалах ажлыг зохион байгуулна.

4.4. Компанийн энгийн хувьцаа нь Нийслэлийн ИТХ-аас холбогдох шийдвэр гарах хүртэл гагцхүү Нийслэлийн ИТХ-ын мэдэлд байх бөгөөд аливаа хэлбэрээр бусдад арилжаалагдахгүй.

4.5. Компани нь цаашид нэмж хувьцаа болон бусад үнэт цаас гаргах бол тэдгээрийн тоо, гаргах хугацаа, нөхцөлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.6. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

4.7. Компанийг үүсгэн байгуулах үе болон нэмэлт хувьцаа гаргах үед гаргасан хувьцааны төлбөрийг мөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө болон хөрөнгийн эрхээр хийж болно.

**ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**



5.1. Компанийн үүсгэн байгуулагч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид "НИТХ" гэх) байна.

5.2. НИТХ нь Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.

5.3. НИТХ нь бүрэн эрхийнхээ хүрээнд энэхүү дүрэм болон хууль, тогтоомжоор компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг өөрийн үйл ажиллагаа явуулах журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3.1. компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

5.3.2. компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.3.3. охин болон хараат компани байгуулах, татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

5.3.4. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

5.3.5. компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

5.3.6. компанийн гаргасан давуу эрхийн хувьцаанаас бусад үнэт цаасыг худалдах, худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;

5.3.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, чөлөөлөх;

5.3.8. төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

5.3.9. хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол тэдгээрийн талаар шийдвэр гаргах;

5.3.10. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

5.4. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг НИТХ-д хэдийд ч тавьж шийдвэрлүүлж болно.

5.5. НИТХ хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа бодлого, шийдвэрээр тогтвортой дэмжиж ажиллана.

5.6. НИТХ болон зөвлөл нь хууль тогтоомж болон энэхүү дүрмээр бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд оролцохгүй.

5.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн бүрэлдэхүүнд багтдаг аж ахуйн үйл ажиллагаа явуулж ашиг олдоггүй эрдэм шинжилгээний ажил, судалгаа, инновац эрхэлдэг нэгж, төвийн санхүүжилтийн асуудлыг НИТХ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

## ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

6.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд 1/3 нь НИТХ-аас, 1/3 нь төрийн албан хаагч, 1/3 нь хараат бус гишүүн байх ба тэдгээрийг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж томилж, чөлөөлнө.

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улирал тутамд хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хурлыг хэдийд ч товлон хуралдуулж болно.

6.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

6.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

6.5.1. компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;

6.5.2. компанийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

6.5.3. бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг батлах;

6.5.4. компанийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох;



6.5.5. компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;

6.5.6. компанийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын дээд хязгаарыг тогтоох;

6.5.7. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;

6.5.8. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах

6.5.9. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, нээж ажиллуулах, татан буулгах, удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

6.5.10. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

6.5.11. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

6.5.12. компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

6.5.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг болон төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дүрэм, журмыг батлах;

6.5.14. компанийн шинээр худалдаж авах болон акталж, данснаас хасах эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх;

6.5.15. худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

6.5.16. компанид орсон орлогыг хуваарилах, хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээг тогтоох, батлах;

6.5.17. компанийн мэдэлд үлдээсэн эрсдэлийн хуримтлалын хэмжээг тодорхойлох, зарцуулах журмыг батлах;

6.5.18. хуульд өөрөөр заагаагүй бол компанийн зүгээс Нийслэлийн төсөвт оруулах орлого буюу ногдол ашгийн хэмжээг тодорхойлох;

6.5.19. их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон хийх эсэх талаар шийдвэр гаргах;

6.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос томилж, чөлөөлнө.

6.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, түүнд хяналт тавих үүргийг хүлээнэ.

6.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас үүрэг болгосны дагуу аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

6.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг хорооны даргын ажлыг хавсран гүйцэтгэхгүй.

6.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдуулна.


6.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх гуравны хоёр (2/3) оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонх гуравны хоёр (2/3)-ын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

6.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зөвхөн өөрийн биеэр хуралд оролцож эрх хэмжээгээ хэрэгжүүлэх бөгөөд өөр этгээдээр төлөөлүүлж хуралд оролцохыг хориглоно.

6.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудал хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

6.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

6.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь цалин, урамшуулалтай байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ нь НИТХ болон холбогдох эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон жишиг хэмжээтэй нийцэхүйц байна.



6.16. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

## ДОЛОО. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирлаар удирдуулсан Захиргааны болон Үйлдвэрлэл технологийн алба, санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга бүхий баг хэрэгжүүлнэ.

7.2. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөл томилж, чөлөөлнө.

7.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх ашгийн төлөө түүнийг Монгол Улс болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

7.4. Гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх удирдлагын гишүүн тус бүртэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд тэдний эрх, үүрэг, цалин, шагнал урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээ болон бусад асуудлыг тусгана.

7.5. Гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох журмыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батална.

7.6. Гүйцэтгэх захирал нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхийг зогсоох тухай шийдвэрийг гаргана.

7.7. Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг гаргаж шийдвэрлэнэ.

7.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

7.8.1. менежментийн өндөр ур чадвартай, 10 (арав)-аас доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай, санхүү эдийн засаг, хүнд үйлдвэрийн салбарын дээд боловсролтой байх;

7.8.2. зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

7.8.3. ял шийтгэлгүй байх;

7.8.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

7.9. Гүйцэтгэх захирал нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

7.9.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа ажлын үр дүнгээ тайлагнан дүгнүүлэх;

7.9.2. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх үүрэгтэй бөгөөд түүний үнэн зөвийг хариуцах;


7.9.3. компанийн дотоод журам, заавар, аргачлал, ажил үүргийн хуваарь баталж мөрдүүлэх, компанийн ажиллагсдад сахилгын шийтгэл ногдуулах;

7.9.4. хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

7.9.6. компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

7.9.7. компанийн бодлого, түүний хэрэгжилттэй холбогдсон асуудлаар НИТХ, Засаг дарга, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

7.9.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний хүрээнд хамаарах асуудлаар компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;



7.9.9. компанийн нууцад хамаарах мэдээлэл, материалын жагсаалт болон нууц хамгаалах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдүүлэх;

7.9.10. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.9.11. гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

7.9.12. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

7.9.13. компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

7.9.14. компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулах;

7.9.15. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

7.9.16. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг хариуцан зохион байгуулах;

7.9.17. компанийн бэлгэдэл, тэмдгийн загварыг батлах;

7.9.20. хууль болон энэхүү дүрэм, гэрээнд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

7.10. Гүйцэтгэх захирал нь эрх, үүргээ түр хугацаанд компанийн бусад эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.11. Компанийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон тооны болон орон тооны бус мэргэжлийн зөвлөх буюу зөвлөх багийг авч ажиллуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж болно.

## НАЙМ.КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

8.1. Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно:

8.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн;

8.1.2. Гүйцэтгэх захирал;

8.1.3. Захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн дарга

8.1.4. Үйлдвэрлэл технологийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга

8.1.5. Санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

8.1.6. Ерөнхий нягтлан бодогч;

8.1.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

8.1.8. Шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцож буй бусад этгээд;


8.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх болон бусад мэдээллийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч энэхүү дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

8.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй байна:

8.3.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;

8.3.2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

8.3.3. үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, хувьцаа эзэмшигч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;



8.3.4. шууд болон шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанид нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

8.3.5. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

8.3.6. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөл, аудиторт мэдэгдэх;

8.3.7. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

8.3.8. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 (арав) хоногийн дотор Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрд 10 (арав) хоногийн дотор компанид мэдэгдэнэ;

8.3.9. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

8.4. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 (гурав) жилийн туршид энэ дүрмийн 11.3.9-д заасан үүргийг хүлээнэ.

## ЕС. КОМПАНИЙН САНХҮҮЖИЛТ БОЛОН НОГДОЛ АШИГ

9.1. Компани нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

9.1.1. Өөрийн үйл ажиллагааны орлого

9.1.2 Хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсан орлогын тодорхой хэсэг;

9.1.2. Паркийн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсний хураамж,

9.1.3. Паркийн хөгжлийн санд бүрдүүлэх хуульд хориглоогүй бусад орлого

9.2. Тухайн санхүүгийн жилийн нийслэлийн төсвийн тухай төслийг НИТХ-д өргөн мэдүүлэхээс 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө нийслэлийн төсөвт компанийн зүгээс төвлөрүүлэх орлогын хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тодорхойлж шийдвэрийг нийслэлийн санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлнэ.

9.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү дүрмийн 13.2-т заасан орлогын хэмжээг тодорхойлохдоо тухайн санхүүгийн жилийн компанийн төсөв, шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал, эрсдэлийн хуримтлалд үлдээх хөрөнгө (болзошгүй, өргөтгөлийн зардал, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зардал, бусад бодит болон нөхцөлт өр төлбөрт шаардагдах хөрөнгө г.м) зэргийг нийт төвлөрүүлсэн хөрөнгөөс хасаж тооцно.

9.4. Нийслэлийн төсөвт компанийн зүгээс төвлөрүүлэх орлого нь энэхүү, дүрмийн 3.1.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэх бөгөөд энэ нь гагцхүү компанийн банкин дахь дансанд төвлөрнө.

9.5. Компани нь тухайн жилийн Төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлсэн орлого буюу ногдол ашгийг Нийслэлийн төсөвт шилжүүлнэ.

9.6. Компанийн тухайн жилийн эрсдэлийн хуримтлалд үлдээх хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрмийн 13.1-д заасан нийт орлогын 5 (таван) хувиас хэтрэхгүй байна.


## АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

10.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

10.2. Компани нь охин компанитай бол нэгдсэн санхүүгийн тайлан гаргана.

10.3. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

10.4. Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.



## АРВАН НЭГ. МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

11.1. Компани өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ;

11.2. Компани дараах мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр жил, хагас жил тутам нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ:

11.2.1. компанийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, гарсан өөрчлөлт;

11.2.2. хагас жилийн болон жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

11.2.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

11.2.4. компанийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

11.2.5. төрөөс олгосон баталгаа болон аливаа бусад санхүүгийн туслалцаа, түүнчлэн компаниас бусдад гаргасан баталгаа, батлан даалтын талаарх мэдээлэл;

11.2.6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

## АРВАН ХОЁР. БУСАД

12.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй аливаа асуудал нь Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдаж, тайлбарлагдана.

12.2. Компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, компанитай гэрээгээр ажиллаж байгаа этгээд компанийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомжид тусгайлан заасан буюу төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд компаниас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглаж эсхүл задруулж болохгүй.

12.3. Компани нь албан хэргийн хөтлөлт болон бичиг баримтыг хадгалах, холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

12.4. Энэхүү дүрмийг зөрчиж гаргасан аливаа шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

